## ХААН СОЁМБО АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/23/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....15
3.5.1 Төсвийн төлөвлөлт....15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл....16
3.5.3 Нэмэлт төсөв....16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн....16
4. АУДИТЫН ТАЙЛАН....16
4.1 Ерөнхий зүйл....16
4.2 Материаллаг байдал....17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....17
4.5.1 Завсрын аудитын талаар....17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн....18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....18
5.1 Төлбөрийн акт....18
5.2 Албан шаардлага....18
5.3 Зөвлөмж....18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/232

танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.ТҮВШИНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Нэмэлт төсвийн гүйцэтгэл 2021 онд 2,371,762.7 мянган төгрөг байсан бол тайлант онд 251,576.4 мянган төгрөгөөр буюу 10.6 дахин буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Эм боох материал дансанд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/556 тоот тушаалаар 121,645.0 мянган төгрөгийн үнэ бүхий 11,700 ширхэг ковид-19 цар тахлыг илрүүлэх түргэвчилсэн оношлуур хуваарилагдаж ирснийг хүлээн авч орлогод бүртгэсэн боловч уг оношлуурын хүчинтэй хугацаа 2023 оны 3 болон 6 дугаар саруудад дуусахаар байна. Ковид-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын 608,522.4 мянган төгрөгийн үнэ бүхий 27,300 ширхэг вакцины үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 86.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийллэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**СТ-1А**

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,110,559,231.51** | **1,101,175,444.74** |
| 33 | **АВЛАГА** | 11,600,000.00 | 00.00 |
| 335 | **Бусад авлага** | 11,600,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 6,080,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,520,000.00 | 00.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,098,959,231.51 | 1,101,175,444.74 |
| 351 | **Түүхий эд материал** | 993,653,688.55 | 1,010,630,115.50 |
| 35130 | Эм боох материал | 993,653,688.55 | 1,010,630,115.50 |
| 354 | **Хангамжийн материал** | 105,305,542.96 | 90,545,329.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 16,218,089.60 | 4,468,039.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,467,665.00 | 4,353,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,768,000.00 | 171.18 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,450,300.00 | 2,208,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 80,401,488.36 | 79,515,118.46 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,764,332,967.94** | **1,672,152,668.09** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,764,332,967.94 | 1,672,152,668.09 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1,554,402,365.94 | 1,463,668,721.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,220,581,767.00 | 1,220,581,767.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -79,942,716.72 | -106,984,472.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 243,587,650.37 | 243,587,650.37 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -67,672,992.02 | -95,383,948.37 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 227,508,399.45 | 226,158,165.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -33,457,106.91 | -63,717,992.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,935,597.50 | 49,042,240.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,866,922.29 | -21,698,534.53 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 18,678,826.00 | 18,678,826.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,950,136.44 | -6,594,979.92 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 209,930,602.00 | 208,483,946.92 |
| 39301 | Програм хангамж | 12,946,550.00 | 12,946,550.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,990,948.00 | -4,437,603.08 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 199,975,000.00 | 199,975,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,874,892,199.45** | **2,773,328,112.83** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **2,399,982.60** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 2,399,982.60 |
| 413 | **Өглөг** | 00.00 | 2,399,982.60 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 2,399,982.60 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,874,892,199.45** | **2,770,928,130.23** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,874,892,199.45 | 2,770,928,130.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 586,507,029.00 | 586,507,029.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 586,507,029.00 | 586,507,029.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,890,536,188.75 | 1,786,571,693.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,890,536,188.75 | 1,890,535,763.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -103,964,069.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 397,848,981.70 | 397,849,407.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** VI=IV+V | **2,874,892,199.45** | **2,773,328,112.83** |

**СТ-2А**

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **13,838,402,468.83** | **5,484,640,669.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,812,794,981.85** | **2,463,320,749.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,812,794,981.85 | 2,463,320,749.90 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,025,607,486.98** | **3,021,319,920.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,230,783,100.00 | 2,774,718,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 794,824,386.98 | 246,601,720.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 182,771,185.98 | 139,203,001.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,996,400.00 | 23,305,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 178,880,700.00 | 80,281,219.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 373,176,101.00 | 3,812,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **12,805,173,334.62** | **5,346,421,367.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,805,173,334.62** | **5,346,421,367.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,536,754,536.82 | 3,549,026,933.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 614,037,129.20 | 612,089,199.00 |
| 210101 | Үндсэн цалин | 391,456,833.00 | 384,211,396.00 |
| 210102 | Нэмэгдэл | 117,417,596.20 | 111,810,622.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 49,665,000.00 | 58,562,000.00 |
| 210104 | Урамшуулал | 55,497,700.00 | 57,505,181.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,370,870.00 | 82,632,096.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,841,859.00 | 58,148,499.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,253,694.00 | 6,120,899.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,816,811.00 | 4,896,699.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,351,002.00 | 1,224,199.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,107,504.00 | 12,241,799.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 132,501,092.00 | 138,900,582.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,858,051.00 | 6,862,095.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,165,041.00 | 65,039,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,478,000.00 | 66,998,847.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 87,617,558.65 | 170,409,795.94 |
| 210401 | Бичиг хэрэг | 22,007,030.00 | 56,022,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,860,727.98 | 62,697,909.82 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,866,632.00 | 6,784,663.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,845,840.00 | 4,694,454.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,037,328.67 | 2,650,628.12 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 37,559,151.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 9,184,962,389.04 | 2,162,703,683.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,184,962,389.04 | 2,162,703,683.55 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,561,400.00 | 41,346,889.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,685,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,561,400.00 | 39,661,889.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 81,924,900.00 | 104,644,460.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 81,924,900.00 | 104,644,460.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 37,131,649.00 | 20,687,332.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,987,070.00 | 12,708,129.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 499,960.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,154.00 | 573,818.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,829,500.00 | 3,706,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 599,925.00 | 599,925.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 302,647,548.93 | 215,612,895.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 222,431,582.00 | 98,313,808.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,234,500.00 | 4,528,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 74,981,466.93 | 112,771,087.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,268,418,797.80 | 1,797,394,434.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,247,788,846.00 | 1,796,774,123.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 67,500,000.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 826,075,912.00 | 1,179,824,637.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1,346,552,934.00 | 609,289,686.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,660,000.00 | 7,659,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,629,951.80 | 620,311.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,033,229,134.21** | **138,219,302.57** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,227,692.07 | 242,183,371.79 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 4,227,692.07 | 242,183,371.79 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -4,227,692.07 | -242,183,371.79 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,029,001,442.14** | **-103,964,069.22** |

**СТ-3А**

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **5,602,545,806.98** | **3,026,319,920.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,602,545,806.98** | **3,026,319,920.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,230,783,100.00 | 2,774,718,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,230,783,100.00 | 2,774,718,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,371,762,706.98 | 251,601,720.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 226,724,505.98 | 139,203,001.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,996,400.00 | 23,305,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,711,865,700.00 | 85,281,219.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 373,176,101.00 | 3,812,500.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **5,569,485,806.98** | **3,013,480,020.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,569,485,806.98** | **3,013,480,020.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,798,167,009.18** | **1,216,085,586.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 652,456,726.20 | 612,089,199.00 |
| 210101 | Үндсэн цалин | 430,636,430.00 | 384,211,396.00 |
| 210102 | Нэмэгдэл | 116,657,596.20 | 111,810,622.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 49,665,000.00 | 58,562,000.00 |
| 210104 | Урамшуулал | 55,497,700.00 | 57,505,181.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,059,073.00 | 82,632,096.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,841,859.00 | 58,148,499.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,329,718.00 | 6,120,899.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,889,606.00 | 4,896,699.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,529,938.00 | 1,224,199.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,467,952.00 | 12,241,799.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 132,501,092.00 | 136,500,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,167,992.00 | 6,862,095.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,855,100.00 | 65,039,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,478,000.00 | 64,598,865.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 91,854,041.98 | 96,088,863.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,076,900.00 | 21,918,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 63,390,909.98 | 51,670,081.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,866,632.00 | 6,784,663.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,172,000.00 | 6,023,809.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,347,600.00 | 9,692,210.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 382,842,120.00 | 5,325,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 376,342,120.00 | 2,802,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,500,000.00 | 2,522,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,389,000.00 | 47,653,788.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,000,000.00 | 5,313,899.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,708,600.00 | 2,582,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,680,400.00 | 39,757,889.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 95,017,224.00 | 99,124,460.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 95,017,224.00 | 99,124,460.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 39,076,179.00 | 21,787,332.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,177,100.00 | 12,708,129.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 499,960.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,154.00 | 573,818.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,584,000.00 | 4,806,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 599,925.00 | 599,925.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 299,971,553.00 | 114,884,148.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 285,364,753.00 | 110,356,148.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,606,800.00 | 4,528,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,771,318,797.80** | **1,797,394,434.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,745,688,846.00 | 1,796,774,123.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,549,000,000.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 826,075,912.00 | 1,179,824,637.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1,346,552,934.00 | 609,289,686.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,060,000.00 | 7,659,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 25,629,951.80 | 620,311.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,629,951.80 | 620,311.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,060,000.00** | **12,839,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **33,060,000.00** | **12,839,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **33,060,000.00** | **12,839,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 33,060,000.00 | 12,839,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 33,060,000.00 | 12,839,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-33,060,000.00** | **-12,839,900.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |

**СТ-4А**

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 586,507,029.00 | 398,686,661.72 | 860,697,066.59 | 1,845,890,757.31 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 837,680.02 | 837,680.02 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **586,507,029.00** | **399,729,690.72** | **861,534,746.61** | 1,847,771,466.33 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -837,680.02 | 00.00 | -837,680.02 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,029,001,442.14 | 1,029,001,442.14 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **586,507,029.00** | **397,848,981.70** | **1,890,536,188.75** | 2,874,892,199.45 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **586,507,029.00** | **397,848,981.70** | **1,890,536,188.75** | 2,874,892,199.45 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -425.59 | -425.59 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **586,507,029.00** | **397,848,981.70** | **1,890,535,763.16** | 2,874,891,773.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 425.59 | 00.00 | 425.59 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -103,964,069.22 | -103,964,069.22 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **586,507,029.00** | **397,849,407.29** | **1,786,571,693.94** | 2,770,928,130.23 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | | 0.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,774,718,200.00 | 2,774,123,149.00 | 595,051.00 | 99.98 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,774,718,200.00 | 2,774,123,149.00 | 595,051.00 | 99.98 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 982,944,000.00 | 982,349,026.00 | 594,974.00 | 99.94 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 612,089,200.00 | 612,089,199.00 | 1 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 387,395,800.00 | 384,211,396 | 3,184,404.00 | 99.18 |
| 210102 | Нэмэгдэл | 116,755,800.00 | 111,810,622 | 4,945,178.00 | 95.76 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 49,665,000.00 | 58,562,000.00 | -8,897,000.00 | 117.91 |
| 210104 | Урамшуулал | 58,272,600.00 | 57,505,181.00 | 767,419.00 | 98.68 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 82,632,100.00 | 82,632,096.00 | 4 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,148,500.00 | 58,148,499.23 | 0.77 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,120,900.00 | 6,120,899.1 | 0.9 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,896,700.00 | 4,896,699.07 | 0.93 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,224,200.00 | 1,224,199.26 | 0.74 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,241,800.00 | 12,241,799.34 | 0.66 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 136,500,600.00 | 136,500,600.00 | 0 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,107,500.00 | 6,862,095.00 | 5,245,405.00 | 56.68 |
| 210302 | Түлш, халаалт | 70,215,200.00 | 65,039,640.00 | 5,175,560.00 | 92.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 54,177,900.00 | 64,598,865.00 | -10,420,965.00 | 119.23 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 42,697,100.00 | 42,696,282.00 | 818 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,266,700.00 | 6,266,600.00 | 100 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,679,600.00 | 17,679,000.00 | 600 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,584,000.00 | 6,784,663.00 | -200,663.00 | 103.05 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,023,900.00 | 6,023,809.00 | 91 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,142,900.00 | 5,942,210.00 | 200,690.00 | 96.73 |
| 2105 | **Нормативт зардал** | 4,370,100.00 | 4,370,100.00 | 0 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,847,600.00 | 1,847,600.00 | 0 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,522,500.00 | 2,522,500.00 | 0 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,519,700.00 | 30,519,309.00 | 391 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,153,900.00 | 10,153,799.00 | 101 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,582,200.00 | 2,582,000.00 | 200 | 99.99 |
| 210604 | Урсгал засвар | 17,783,600.00 | 17,783,510.00 | 90 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,518,800.00 | 8,515,700.00 | 3,100.00 | 99.96 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,518,800.00 | 8,515,700.00 | 3,100.00 | 99.96 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,801,100.00 | 21,787,332.00 | 13,768.00 | 99.94 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,712,500.00 | 12,708,129.00 | 4,371.00 | 99.97 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 499,960.00 | 40 | 99.99 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 576,600.00 | 573,818.00 | 2782 | 99.52 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 | 0 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,813,000.00 | 4,806,500.00 | 6,500.00 | 99.86 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | 599,925.00 | 75 | 99.99 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,815,300.00 | 43,238,408.00 | 576892 | 98.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,284,400.00 | 38,710,408.00 | 573992 | 98.54 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн зардал | 4,530,900.00 | 4,528,000.00 | 2900 | 99.94 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,791,774,200.00 | 1,791,774,123.00 | 77 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,791,774,200.00 | 1,791,774,123.00 | 77 | 100.00 |
| 213207 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,179,824,700.00 | 1,179,824,637.00 | 63 | 100.00 |
| 213208 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 609,289,700.00 | 609,289,686.00 | 14 | 100.00 |
| 213209 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 2,659,800.00 | 2,659,800.00 | 0 | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,774,718,200.00 | 2,774,123,149.00 | 595,051.00 | 99.26 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,774,718,200.00 | 2,774,123,149.00 | 595,051.00 | 99.26 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,774,718,200.00 | 2,774,123,149.00 | 595,051.00 | 99.26 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 0 | 0 | 0 | 0.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 | 1000.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 43 | 43 | 0 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 35 | 35 | 0 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 | 0 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 251,601,720.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 251,601,720.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 246,576,460.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 53,392,581.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,651,500.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 33,991,081.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 3,750,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 955,000.00 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 955,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 29,974,379.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,474,379.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 90,608,760.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,608,760.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,645,740.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,645,740.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 25,260.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,260.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000,000.00 |
| | Бусад урсгал шилжүүлэг | 5,000,000.00 |
| | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 5,000,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 251,601,720.00 |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | 251,601,720.00 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 139,203,001.00 |
| 350013 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,305,000.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 85,281,219.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,812,500.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 43.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 1.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 35.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.00 |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 онд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, чанарын бодлогыг шинэчлэн баталсан байна. Улсдаа тэргүүлсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч төрийн байгууллага болох, нотолгоонд суурилсан

нэмэгдүүлж, тасралтгүй сайжруулалтыг эрхэмлэсэн цогц бодлого, арга зүйгээр хангаж ажиллах зорилготой Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 07 сарын 08-ны өдрийн А/87 тоот тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан ажилласан байна. Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 болон 29.5 дахь заалтаар олгодог "Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх тэтгэмжийн олголтод хяналт хийж зөвлөмж өгсөн байна.
Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101,564.1 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 11.600,0 | 0.00 | -11.600,0 |
| Бараа материал | 1,098,959.2 | 1,101,175.4 | 2,216.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,764,332.9 | 1,672,152.6 | -92,180.3 |
| **Нийт хөрөнгө** | **2,874,892.2** | **2,773,328.1** | **-101,564.1** |
| Өр төлбөр | 0 | 2,399.9 | 2,399.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 586,507.0 | 586,507.0 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,874,892.2** | **2,773,328.1** | **-101,564.1** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данснуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 595.0 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.
- Бараа материал данс өмнөх оноос 2,216.2 мянган төгрөгөөр өссөн корона вирусын эсрэг дархлаажуулалтын вакцин, түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэлттэй холбоотой мөн эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.

- Үндсэн хөрөнгө данс 92,180.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 45,320.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, сумын эрүүл мэндийн төвүүдэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын 2022.12.28-ны өдрийн №А/92 захирамжаар 32,124.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 14,414.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Үндсэн хөрөнгийн элэгдэл 37,789.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны авлага 11,600.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Тайлант онд цэвэр бохир усны өр 2,399.9 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь гадна бохирын цооног хөлдсөнтэй холбоотойгоор үүссэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,774,718.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөсөн. Нийт зардлыг 2,774,718.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 07-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,774,718.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Нийт 2,774,718.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,774,123.1 мянган төгрөгийг зарцуулж 595.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,774,123.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 954,362.4 | 953,981.4 | 381.0 | 99.9 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,791,774.2 | 1,791,774.1 | 0.1 | 100 |
| 3 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал | 28,581.6 | 28,367.6 | 214.0 | 99.4 |
| | Нийт дүн | 2,774,718,2 | 2,774,123.1 | 595.1 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл 2021 онд 2,371,762.7 мянган төгрөг байсан бол тайлант онд 251,576.4 мянган төгрөгөөр буюу 10.6 дахин буурсан байна.

Нэмэлт зардлын дансаар

- Дээд шатны төсвийн захирагчаас 80,281.2 мянган төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 139,203.0 мянган төгрөг,
- Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 23,305.0 мянган төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,812.5 мянган төгрөг нийт 246,601.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх заавар”-ын сургалтын зардлаас 7,900.0 мянган төгрөгийг буцааж, 25.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансны өмнөх оны 11,600.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### .5.4 *Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

- ДЭМБ-ийн санхүүжилтээр “Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний багийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн”-ий зардал 69,491.8 мянган төгрөг, дархлаажуулалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх 6,260.1 мянган төгрөг, “Эх, хүүхдийн эндэгдлээс урьдчилан сэргийлэх сургалт”-ын зардал 25,754.0 мянган төгрөг нийт 101,505.9 мянган төгрөг,
- Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сүрьеэгийн үзлэгийн зардал 17,697.1 мянган төгрөг
- ХӨСҮТ-өөс НҮБ-ийн санхүүжилтээр “Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын нэмэлт тунг идэвхжүүлэх” үйл ажиллагааны зардал 17,500.0 мянган төгрөг, “Вакцин биобэлдмэлийн өрөөний засвар”-ын зардал 25,474.4 мянган төгрөг, “Вакцин менежмент”-ийн сэдвээр 5 аймагт хийх сургалтын зардалд 28,603.8 мянган төгрөг
- Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх заавар” сургалтын зардал 28,900.0 мянган төгрөг
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас “Хамгаалагдсан Хөвсгөл” арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлыг устгах ажлыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын зардал 5,000.0 мянган төгрөг, Сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн бэлдмэлийн хангамж нөөц бэлтгэхэд 18,305.0 мянган төгрөгийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,805,173.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 256,103.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар эдийн засгийн ангилал хооронд 799.5 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан, бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого, зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор орлого, зардалд бүртгэсэн 13,100.0 мянган төгрөгийг тус тус залруулж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй тул өөрийн байгууллагад тохируулан шинэчлэн боловсруулах гэсэн 1 зөвлөмж өгсөн. Эрүүл мэндийн яаманд бодлогын баримт бичиг боловсруулагдаж гүйцэтгэл 85.0 хувьтай хэрэгжиж байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,742,412.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,730,812.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,600.0 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүлсэн байна.

Тайлант онд 11,600.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж авлагыг бүрэн барагдуулсан байна.

*Хүснэгт 4* Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 11,600.0 | 1 | 11,600.0 | 100 |
| **Нийт дүн** | 1 | 11,600.0 | 1 | 11,600.0 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эм боох материал дансанд ЭМЯ-наас ЭМСайдын тушаалаар 121,645.0 мянган төгрөгийн үнэ бүхий 11700 мянган ширхэг ковид-19 цар тахлыг илрүүлэх түргэвчилсэн оношлуур хуваарилагдаж ирснийг орлогод бүртгэсэн болович уг оношлуурын хугацаа 2023 оны 3 болон 6 дугаар саруудад дуусахаар байна. Ковид-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын 608,522.4 мянган төгрөгийн үнэ бүхий 27300 мянган ширхэг вакцины үлдэгдэл тайлагнасан байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,399.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс, залруулсан алдаа байхгүй дахин давтан гаргахгүй байх 2,399.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 2,399.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өр төлбөр үүсгэсэн | 1 | 2,399.9 | | | | | 1 | 2,399.9 | | | | |
| Дүн | 1 | 2,399.9 | | | | | 1 | 2,399.9 | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО: